



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН**

**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

**2020 оны 5 дугаар сарын 20-ны өдөр**

**Дугаар 02**

**Мөрөн**

**ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ**

**ТОГТООХ ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “д”, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйийн 6.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус XII хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4-35.1.22 дахь заалт, 35.2-35.5 дахь хэсэгт заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан тэмдэгтийн хураамжийг мөрдөж ажиллахыг аймгийн Засаг дарга (Л.Ганболд)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын бүрдүүлбэрийг хангаж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, бүртгүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Ц.Гончиг)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 98 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**ДАРГА**

**Л.ТӨМӨРБААТАР**





Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны

2020 оны 2 дугаар тогтоолын хавсралт


Хуулийн зүйл заалт	Тэмдэгтийн хураамжийн төрөл	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар тогтоосон хязгаар		аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус XII хуралдааны тогтоол	
		Доод	Дээд	төгрөгөөр	Тайлбар
35.1.4	Агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход	200,000	500,000	500,000	
35.1.5	Тамхи бөөнөөр худалдах тусгай зөвшөөрөл олгоход	100,000	250,000	250,000	
	Тамхи жижиглэнгээр худалдах тусгай зөвшөөрөл олгоход			100,000	
35.1.6	Ус хэрэглэгчид газрын доорх ус ашиглалтын цооног өрөмдөх зөвшөөрөл олгоход	96,000	240,000	150,000	
35.1.7	Ус ашиглагчтай гэрээ байгуулж, 100 шоо метрээс бага ус ашиглуулах гэрчилгээ олгоход гэрээний жил тутамд	32,000	80,000	40,000	
	Гэрээг сунгахад			30,000	
35.1.8	усны барилга байгууламж гэрээгээр эзэмших, ашиглах эрх олгох, эрх сунгахад	40,000	100,000	50,000	
35.1.9	Ан амьтныг эзэмших зөвшөөрөл олгоход	48,000	120,000	100,000	
35.1.10	Нэн ховор, ховор амьтныг судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, гоо зүйн зориулалтаар /ажиглаж судлах, тэмдэг тавих, зурах, зураг авах зэрэг хэлбэрээр/ амьтныг гэмтээлгүйгээр амьдрах орчныг нь алдагдуулалгүйгээр ашиглах зөвшөөрөл олгоход	40,000	100,000	100,000	



35.1.11	Хөрс бүрдүүлэх, байгалийг ариутгах, ургамалд тоос хүртээх зэрэгт амьтны амьдралын үйл ажиллагааны хэрэгтэй чанарыг ашиглахдаа амьтанд гэмтэл учруулахгүйгээр гүйцэтгэх ба ийм хэлбэрээр амьтныг ашиглах зөвшөөрлийг олгоход	8,000	20,000	20,000	
35.1.12	Ан амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах иргэн, хуулийн этгээдэд суман дахь байгаль хамгаалагч гарал үүслийн тодорхойлолт олгоход	1,000	5,000	5,000	
35.1.13	Үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын ан амьтан агнах, барих гэрээ байгуулахад	400,000	1,000,000	1,000,000	
35.1.14	Мал бүхий иргэн, хуулийн этгээдээс төв суурин газарт борлуулах зорилгоор оруулж байгаа олон тооны мал, мах бэлтгэхэд гарал үүслийн гэрчилгээ олгоход	0-10 толгой мал бол	1,000	5,000	3,000
		10-аас дээш тооны толгой мал бол	1,000	5,000	5,000
		10-аас дээш тооны малын толгой тутамд	50	100	60
					5000+ Толгой тутамд 60 төгрөг
35.1.15	Ховор ургамлыг ахуйн болон судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход килограмм тутамд	1,200	3,000	3,000	3,000
35.1.16	Элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход	1,000	2,000	2,000	2,000
35.1.17	Элбэг ургамлыг гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд түүж бэлтгэхэд нойтон жингийн килограмм тутамд	4,000	10,000	10,000	10,000
35.1.18	Ойн дагалт нөөцийг ашиглах эрхийн бичиг олгоход	0-10 килограмм бол	1,000	2,000	1,500
		10 килограммаас дээш бол 10 килограммаас дээш тооцсон хэмжээний килограмм тутамд	50	100	80
35.1.19	Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг хувиараа эрхлэх, малын үр, үр хөврөл, мал эмнэлгийн зориулалттай эм бэлдмэл үйлдвэрлэх үйл ажиллагаа	этгээдэд олгоход	200,000	500,000	400,000



	зөвшөөрлийг хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн нутагт явуулахад зохих байгууллагын дүгнэлтийг үндэслэн	иргэнд	160000	400000	300,000	
35.1.20	Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг хувиараа эрхлэх, малын үр, үр хөврөл, мал эмнэлгийн зориулалттай эм бэлдмэл үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сум, дүүргийн нутагт яvuулахад зохих байгууллагын дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга олгоход		80,000	200,000	150,000	
35.1.21	мал, түүний үржлийн чанар, ашиг шим, эрүүл мэнд болон малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд үзлэг, шинжилгээ хийж гарал үүсэл, чанарыг тодорхойлон гэрчилгээ олгоход		2,000	5,000	3,000	
35.1.22	Рашаан ашиглах, савлах зөвшөөрөл олгоход		125,000	320,000	300,000	
35.2.1	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгоход	аймгийн төвийн суманд	240,000	600,000	600,000	
		бусад суманд	120,000	300,000	300,000	
	Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад	аймгийн төвийн суманд	80,000	200,000	200,000	
		бусад суманд	40,000	100,000	100,000	
35.2.2	Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгоход	аймгийн төвийн суманд	80,000	200,000	200,000	
		бусад суманд	40,000	100,000	100,000	
	тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад	аймгийн төвийн суманд	30,000	70,000	70,000	
		бусад суманд	16,000	40,000	40,000	
35.2.3	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход	аймгийн төвийн суманд	320,000	800,000	800,000	
		бусад суманд	200,000	500,000	500,000	
	Тусгай зөвшөөрлийн	аймгийн төвийн суманд	160,000	400,000	400,000	



	хугацаа сунгахад	бусад суманд	80,000	200,000	200,000	
35.2.4	Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаагар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход	аймгийн төвийн суманд	160,000	400,000	400,000	
		бусад суманд	100,000	250,000	250,000	✓
	Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад	аймгийн төвийн суманд	80,000	200,000	200,000	
		бусад суманд	50,000	120,000	120,000	
35.4	Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимиийн архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход		40,000	100,000	100,000	
35.5.1	Мод, модон түүхий эдийн гарал үүслийн гэрчилгээ олгоход	6 м <sup>3</sup> хүртэл	1,000	3,000	3,000	багцаар
		6-10 м <sup>3</sup> хүртэл	1,500	4,500	4,500	
		10-20 м <sup>3</sup> хүртэл	2,000	6,000	6,000	
		20-60 м <sup>3</sup> хүртэл	5,000	15,000	15,000	
35.5.2	Ойгоос хэрэглээний мод бэлтгэх эрхийн бичиг олгоход	8 м <sup>3</sup> хүртэл	500	4,500	2,500	багцаар
		8-10 м <sup>3</sup> хүртэл	1,000	6,000	3,000	
		10-20 м <sup>3</sup> хүртэл	500	10,500	5,500	
		20-30 м <sup>3</sup> хүртэл	1,000	15,000	10,000	
35.5.3	Ойгоос түлээ бэлтгэх эрхийн бичиг олгоход	0-10 м <sup>3</sup>	1,000	3,000	2,000	багцаар
		10-20 м <sup>3</sup>	200	3,600	2,500	
		20-30 м <sup>3</sup>	500	4,500	3,000	
35.5.4	Арчилгаа, цэвэрлэгээний журмаар бэлтгэсэн модонд гарал үүслийн гэрчилгээ олгоход	0-10 куб метр бол	1,000	2,000	1,500	багцаар
		10 куб метрээс дээш бол	1,000	2,000	1,500	
		10-аас дээш сийрэг куб метр тутамд	100	150	150	1500+ м <sup>3</sup> тутамд 150 төгрөг
35.5.5	Ойгоос бэлтгэсэн гуалин, шургааг, дунз, зүсмэл материалыг өөр аймаг, сум, хот, суурингийн хооронд тээвэрлэх, худалдах, мод,	0-10 куб метр бол	1,000	2,000	2,000	багцаар
		10-аас дээш куб метр тутамд	100	150	150	2000+ м <sup>3</sup> тутамд 150 төгрөг



материалын гарал үүслийн гэрчилгээ олгоход					
---	--	--	--	--	--

